

## 5-Р АНГИЙН СУРАГЧДЫН СУРАХ АРГА БАРИЛ ЭЗЭМШСЭН БАЙДЛЫН ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭ

Ш.Ичинхорлоо, профессор, МУБИС

**Аннотация:** В данной статье рассматривается проблема оценивания учащимися усвоенных учебных умений. Для этого мы разработали специальный методический материал, который раздали учащимся 5-ого класса. В данный методический материал мы включили следующие учебные умения: 1/ организационные умения, 2/ умственные умения, 3/ общеучебные умения, 4/ умения находить информацию из различных источников. В эти 4 умения мы включили 50 учебных действий. Разработанный нами материал мы раздали 45 учащимся 5-ого класса. Для установления самооценки учащимися степени усвоения учебных умений мы использовали 4 степени усвоения. Например, 1/ хорошо, 2/средне, 3/ плохо, 4/ не усвоено.

После обработки выполненного учащимися материала было установлено, что 41,5% учащихся усвоили учебные умения хорошо, 36,6% в средней степени, 15,6% плохо, 5,9% не владеют учебными умениями. Учащиеся 5-ого класса хорошо усвоили следующие учебные умения: ставить перед собой цель успешно учиться, умеют мысленно представить учебный материал, понимают почему они учатся, умеют хорошо слушать, умеют находить нужную информацию от своих друзей и т.д. Учащиеся 5-ого класса не владеют следующими учебными умениями. Например, распределять свое время, не имеют распорядок дня, находить главную идею в прочитанном материале, дать определение новому понятию, использовать разные примеры, факты, исправлять свою ошибку и т.д.

**Түлхүүр үг:** Сурагч сурахуйгаа төлөвлөн зохион байгуулах арга барил, оюун ухааны үйл ажиллагааны арга барил, сурах ерөнхий арга барил, мэдээллийн эх үүсвэрээс суралцах арга барил

### Удиртгал

Уг судалгааны зорилт бол ЕБС-ийн 5-р ангийн сурагчид сурах арга барилыг хэр эзэмшсэн байдлаа өөрсдөө үнэлэх явдал юм.

Асуудал нь өнөөгийн их мэдээллийн эрин үед сурагч сургуульд суралцаж байх үеэс бие дааж сурах арга барилыг эзэмших шаардлагатай болсон. Ингэвэл тэд цаашид мэдлэг боловсролоо насан туршдаа дээшлүүлэх боломжтой төдийгүй сурагчид эзэмшсэн сурах арга хэр бодитой үнэлж байгаа байдлыг илрүүлэх зэрэг болно.

Сурагчид сурах арга эзэмшсэн байдлыг тогтоох аргачлал шинээр боловсруулсан бөгөөд түүнд 4 бүлэг, нийт 50 арга барилыг багтаав. Судалгааг 5-р ангийн 45 сурагчдаас авлаа.

Уг өгүүллийг бичихэд судалгааны аргачлал боловсруулж, түүгээр сурагчдаас судалгаа авах, судалгааны материалд боловсруулалт хийх, тайлбар өгөх, дүгнэлт хийх зэрэг аргыг хэрэглэсэн болно.

### Үндсэн хэсэг

Мэдээллийн эрин үед сурагч сурах арга барил эзэмших нь сургалтын тэргүүн зэргийн зорилт болсон байна (Лурье, 1990, х.20).

Сурагч сурах арга барил эзэмшинэ гэдэг нь

тэрээр уншиж бичиж чаддаг байхаас илүү өргөн хүрээтэй зүйл билээ. Тухайлбал, энэ чиглэлийн судалгааны ном зохиолд сурах арга барилын дараах төрлийг авч үзсэн байдаг. Эдгээр нь сурагч 1/ сурахуйг төлөвлөн зохион байгуулах арга барил (Ичинхорлоо, 2012, х.16), 2/ оюун ухааны үйл ажиллагааны арга барил (Загдаа, 1987, х.50-54), 3/ сурах ерөнхий арга барил (Лошкарёва, 1990. х.23), 4/ мэдээллийн эх үүсвэрээс сурах арга барил (Ичинхорлоо, 1996). Эдгээр төрлийн сурах арга нь дотроо олон арга барилаас бүрдэнэ. Эдгээр арга барилыг 5 дугаар ангийн сурагч хэр эзэмшсэн байдлыг тогтоох судалгааг 2015 оны 12дугаар сард явууллаа. Уг судалгааг авахдаа өөрийн урьдчилан боловсруулсан аргачлалыг сурагчдад өгч бөглүүлсэн юм. Ингэхдээ арга барил тус бүрийн хэмжээсжүүлэлтийг 4 түвшинд хийсэн. Уг сурах арга барил 1/ сайн, 2/ дунд зэрэг, 3/ тааруухан, 4/ байхгүй. Энэхүү аргачлалаар 5 дугаар ангийн 45 сурагч 4 төрлийн нийт 50 арга барилыг хэр эзэмшсэнээ өөрсдөө үнэлсэн болно.

Судалгааны зорилт: 5 дугаар ангийн сурагч сурах аргыг хэр эзэмшсэн байдлыг тогтоох, анхаарч сайжруулах зүйлийг илрүүлэх.

## 1. Сурагч сурахуйгаа төлөвлөн зохион байгуулах арга барил эзэмшсэн байдал

## Хүснэгт 1

| № | Арга барил                                 | Сайн  | Дунд  | Тааруу | Байхгүй |
|---|--------------------------------------------|-------|-------|--------|---------|
| 1 | Өөрийн өмнө амжилттай сурах зорилт тавьдаг | 64,4% | 31,1% | 4,4%   | -       |
| 2 | Зорилтоо хэрэгжүүлэх төлөвлөгөө хийдэг     | 20%   | 64,4% | 13,3%  | 2,2%    |
| 3 | Төлөвлөсөн ажлын дэс дарааллыг гаргадаг    | 37,7% | 35,5% | 20%    | 6,6%    |
| 4 | Ажлын цаг хугацааг хуваарилдаг             | 51,1% | 33,3% | 8,8%   | 6,6%    |
| 5 | Цагийн хуваарьтай                          | 40%   | 37,7% | 15,5%  | 6,6%    |
| 6 | Өөрийгөө дайчилдаг                         | 53,3% | 28,8% | 17,7%  | -       |
|   | Дундаж үзүүлэлт                            | 44,4% | 38,4% | 13,2%  | 3,6%    |

Хүснэгтээс: сайн гэсэн түвшинд хамгийн өндөр тоон үзүүлэлт бол сурагч өмнөө амжилттай суралцах зорилт тавьдаг-64,4%, дунд зэрэг гэсэн түвшинд зорилтоо хэрэгжүүлэх төлөвлөгөө хийдэг-64,4%, тааруухан өөрийгөө дайчилдаг арга барил-17,7% байна. Энэ бүхнээс ямар зүйл хэлж болох вэ? гэвэл

1/ 5 дугаар ангид сурагчид амжилттай суралцъя гэж боддог юм байна,

2/ сурагчдын сурахуйгаа төлөвлөн зохион байгуулах арга барилын дундаж үзүүлэлтийг гаргавал: сайн 44,4%, дунд 38,4%, тааруухан 13,2%, үгүй 3,6% тус тус байгаа нь нийт багш нар энэ бүлэг арга барилд анхааран ажиллах шаардлагатай,

3/ энэ аргачлал нь сурагчдын өөрийн үнэлгээ байсан учир үзүүлэлтүүд бодит байдлаас арай өндөр гарсан байх магадлалтай.

Сурагч оюун ухааны үйл ажиллагааны арга барил эзэмшсэн байдал

## Хүснэгт 2

| № | Арга барил                           | Сайн  | Дунд  | Тааруу | Байхгүй |
|---|--------------------------------------|-------|-------|--------|---------|
| 1 | Юмс үзэгдлийг задлан шинжилдэг       | 26,6% | 44,4% | 20%    | 8,8%    |
| 2 | Юмс үзэгдлийг харьцуулдаг            | 48,8% | 33,3% | 15,5%  | 2,2%    |
| 3 | Юмс үзэгдлийг жишдэг                 | 35,5% | 37,7% | 20%    | 8,8%    |
| 4 | Юмс үзэгдлийг төсөөлөн боддог        | 57,7% | 11,1% | 20%    | 11,1%   |
| 5 | Юмс үзэгдлийг ургуулан боддог        | 46,6% | 35,5% | 15,5%  | 2,2%    |
| 6 | Юмс үзэгдлийг ангилан бүлэглэдэг     | 28,8% | 42,2% | 24,4%  | 4,4%    |
| 7 | Юмс үзэгдлийн гол шинжийг олж чаддаг | 24,4% | 44,4% | 20%    | 11,1%   |
| 8 | Юмс үзэгдлийг ерөнхийлдөг            | 22,2% | 46,6% | 26,6%  | 4,4%    |
|   | Дундаж үзүүлэлт                      | 36,3% | 36,9% | 20,2%  | 6,6%    |

Хүснэгтээс: сайн гэсэн үзүүлэлтийн хамгийн өндөр тоон үзүүлэлт бол сурагчдын төсөөлөн бодох чадвар 57,7%, дунд-юмс үзэгдлийг ерөнхийлдөг 46,6%, тааруухан-ангилан бүлэглэх арга 24,4% зэрэг байв. Үүнээс үзэхэд оюун ухааны үйл ажиллагааны зарим арга барилыг 5 дугаар ангийн сурагчид боломжийн эзэмшиж байгаа юм байна.

Дундаж үзүүлэлтийг авч үзвэл: сайн 36,3%, дунд 36,9%, тааруухан 20,2% байгаа зэрэг нь оюун ухааны үйл ажиллагааны арга барилыг сурагчдад илүү сайн эзэмшүүлэхэд багш бүр анхаарч ажиллах шаардлага байна.

Сурагч сурах ерөнхий арга барил эзэмшсэн байдал

## Хүснэгт 3

| № | Арга барил                                          | Сайн  | Дунд  | Тааруу | Байхгүй |
|---|-----------------------------------------------------|-------|-------|--------|---------|
| 1 | Би сурах хэрэгцээгээ ойлгож ухаардаг                | 75,5% | 22,2% | 2,2%   | -       |
| 2 | Хичээлд идэвх санаачлагатай оролцдог                | 60%   | 33,3% | 6,6%   | -       |
| 3 | Хичээлийн бус цагаар ном уншдаг                     | 55,6% | 31,1% | 8,8%   | 4,4%    |
| 4 | Номын эхийг уншаад ойлгодог                         | 53,3% | 35,5% | 6,6%   | 4,4%    |
| 5 | Номын эхээс өөртөө хэрэгтэй мэдээлэл олж авч чаддаг | 62,2% | 31,1% | 6,6%   | -       |

|    |                                                                              |       |       |       |       |
|----|------------------------------------------------------------------------------|-------|-------|-------|-------|
| 6  | Эхийг уншаад хэрэгтэй зүйлээ тэмдэглэж авдаг                                 | 22,2% | 55,5% | 22,2% | -     |
| 7  | Хэрэгтэй мэдээллийг цээжлэн тогтоодог                                        | 24,4% | 48,8% | 20%   | 6,6%  |
| 8  | Алдаагүй бичиж чаддаг                                                        | 20%   | 44,4% | 26,6% | 8,8%  |
| 9  | Найруулан бичиж чаддаг /эргэцүүлэл .../                                      | 44,4% | 26,6% | 22,2% | 6,6%  |
| 10 | Санаа бодлоо бусдад ойлгомжтой ярьж чаддаг                                   | 28,8% | 42,2% | 24,4% | 4,4%  |
| 11 | Бусдын яриаг анхааралтай сонсдог                                             | 64,4% | 26,6% | 6,6%  | 2,2%  |
| 12 | Бусадтай боловсон харилцан ярилцдаг                                          | 48,8% | 42,2% | 8,8%  | -     |
| 13 | Сонссон/уншсан зүйлийн гол санааг олж чаддаг                                 | 40%   | 35,5% | 22,2% | 2,2%  |
| 14 | Сонссон/уншсан зүйлийн ач холбогдлыг ухаарч тодорхойлдог                     | 35,5% | 20%   | 20%   | 2,2%  |
| 15 | Сонссон/уншсан зүйлдээ дүгнэлт хийдэг                                        | 26,6% | 46,6% | 20%   | 6,6%  |
| 16 | Оновчтой асуулт тавьж чаддаг                                                 | 33,3% | 40%   | 20%   | 6,6%  |
| 17 | Жишээ, тоо, баримтыг ашиглаж чаддаг                                          | 33,3% | 35,5% | 17,7% | 13,3% |
| 18 | Шинэ мэдээ мэдээлэл хайж олдог                                               | 48,8% | 37,7% | 11,1% | 2,2%  |
| 19 | Шинэ санаа, арга зам дэвшүүлж чаддаг                                         | 37,7% | 35,5% | 22,2% | 4,4%  |
| 20 | Шинэ ухагдахуунд тодорхойлолт өгч чаддаг                                     | 11,1% | 48,8% | 24,4% | 15,5% |
| 21 | Мэдлэг чадвараа хянаж чаддаг                                                 | 42,2% | 33,3% | 17,7% | 6,6%  |
| 22 | Мэдлэг чадварт байгаа алдаа дутагдлаа би өөрөө засч залруулдаг               | 44,4% | 28,8% | 26,6% | -     |
| 23 | Өөрийн мэдлэг чадвараа би бодитой үнэлдэг                                    | 44,4% | 37,7% | 15,5% | 2,2%  |
| 24 | Дасгал, даалгаврыг бүтээлчээр гүйцэтгэдэг                                    | 51,1% | 40%   | 8,8%  | -     |
| 25 | Өөрийн зан байдал, харилцаа зэрэгт буй алдаа, дутагдлыг засч залруулж чаддаг | 22,2% | 57,7% | 15,5% | 20%   |
| 26 | Өөрт тохиолдож байгаа сурах бэрхшээлийг даван туулах чадвартай               | 51,1% | 31,1% | 17,7% | -     |
| 27 | Суралцахуйн аливаа асуудлыг шийдвэрлэх чадвартай                             | 20%   | 68,8% | 8,8%  | 2,2%  |
| 28 | Багаар хамтран ажиллаж чаддаг                                                | 75,5% | 15,5% | 6,6%  | 4,4%  |
|    | Дундаж үзүүлэлт                                                              | 40,8% | 37,5% | 15,5% | 6,2%  |

Сурах арга дотор “сурах ерөнхий арга барил” голлох байр суурь эзэлдэг. Түүнд олон арга барил багтдагаас бид 28 арга барилыг сонгон авч судалгаа хийлээ.

Сурах ерөнхий арга барилаас сурагчдын “сайн” эзэмшсэн арга барилд:

Сурах хэрэгцээгээ ойлгодог-75,5%

Бусдын яриаг анхааралтай сонсдог-64,4%

Идэвх санаачлагатай-60% байна.

Гэтэл ухагдахуунд тодорхойлолт өгөх гэсэн чухал арга барил 11,1%, алдаагүй бичих гэсэн арга барил 20% байгаа нь багш нарын анхаарал татах зүйл мөн болно.

Сурах ерөнхий арга барилаас “дунд зэрэг” эзэмшсэн арга барилд:

Суралцахуйн аливаа асуудлыг шийдвэрлэх чадвартай-68,8%,

Өөрийн зан байдал, харилцаа зэрэгт буй алдаа дутагдлыг засч залруулж чаддаг-57,7 %,

Эхийг уншаад хэрэгтэй зүйлийг тэмдэглэж

авдаг-55,5% байна.

Гэвч энэ хэсэгт сурагчдын багаар ажиллах чадвар 15,5%, сонссон/уншсан зүйлийн ач холбогдлыг ухаарч тодорхойлдог 20% байгаа зэрэгт багш нар анхаарч ажиллах шаардлага байна.

Сурах ерөнхий арга барил дотор “тааруухан” эзэмшсэн арга барилд:

Алдаагүй бичдэг-26,6%

Мэдлэг чадварт нь байга алдаа дутагдлыг засч залруулж чаддаг-26,6% байгаа зэрэг бид бүхний анхаарч, сайжруулах шаардлагатай зүйл мөн.

Сурах ерөнхий арга барилын дундаж үзүүлэлтийг авч үзвэл: сайн 40,8%, дунд 37,5%, тааруухан 15,5%, байхгүй 6,2% тус тус байгаа нь тийм ч боломжийн сайн үзүүлэлт хараахан биш юм.

Сурагч мэдээллийн эх үүсвэрээс суралцах арга барил эзэмшсэн байдал

## Хүснэгт 4

| №               | Арга барил                                                      | Сайн  | Дунд  | Тааруу | Байхгүй |
|-----------------|-----------------------------------------------------------------|-------|-------|--------|---------|
| 1               | Бусад хүмүүсийн ярианаас өөртөө хэрэгтэй мэдээлэл олж авдаг     | 62,2% | 26,6% | 2,2%   | 8,8%    |
| 2               | Сонин сэтгүүлээс өөртөө хэрэгтэй мэдээлэл олж авдаг             | 53,3% | 35,5% | 8,8%   | 2,2%    |
| 3               | Толь бичиг, лавлах ашиглаж хэрэгтэй мэдээлэл олж авдаг          | 42,2% | 33,3% | 15,5%  | 8,8%    |
| 4               | Интернетээс хэрэгтэй мэдээлэл олж авдаг                         | 42,2% | 24,4% | 20%    | 13,3%   |
| 5               | Радио телевизийн нэвтрүүлгээс хэрэгтэй мэдээлэл олж авдаг       | 33,3% | 40%   | 17,7%  | 8,8%    |
| 6               | Байгалийн юмс үзэгдлийг ажиглан ... хэрэгтэй мэдээлэл олж авдаг | 35,5% | 51,1% | 6,6%   | 6,6%    |
| 7               | Нийгмийн юмс үзэгдлийг ажиглан... хэрэгтэй мэдээлэл олж авдаг   | 22,2% | 40%   | 31,3%  | 6,6%    |
| 8               | Найз нөхдөөс хэрэгтэй мэдээлэл олж авдаг                        | 68,8% | 20%   | 6,6%   | 4,4%    |
| Дундаж үзүүлэлт |                                                                 | 44,8% | 33,8% | 13,5%  | 7,4%    |

Хүснэгтээс үзвэл 5 дугаар ангийн сурагчдын мэдээллийн гол эх сурвалж бол найз нөхдийн яриа байна.

Сурагч мэдээллийн эх үүсвэрээс суралцах арга барилын дундаж үзүүлэлтийг авч үзвэл: сайн 44,8%, дунд 33,8%, тааруухан 13,5%, байхгүй 7,4%-тай байна.

## СУДАЛГААНЫ ҮР ДҮН, ДҮГНЭЛТ

5 дугаар ангийн сурагчдаас авсан сурах арга барил эзэмшсэн байдлын өөрийн үнэлгээний дундаж үзүүлэлтийг авч үзвэл:

## Хүснэгт 5

| №               | Арга барил                                      | Сайн  | Дунд  | Тааруу | байхгүй |
|-----------------|-------------------------------------------------|-------|-------|--------|---------|
| 1               | Сурахуйгаа төлөвлөн зохион байгуулах арга барил | 44,4% | 38,4% | 13,2%  | 3,6%    |
| 2               | Оюун ухааны үйл ажиллагааны арга барил          | 36,3% | 36,9% | 20,2%  | 6,6%    |
| 3               | Сурах ерөнхий арга барил                        | 40,8% | 37,5% | 15,5%  | 6,2%    |
| 4               | Мэдээллийн эх үүсвэрээс суралцах арга барил     | 44,8% | 33,8% | 13,5%  | 7,4%    |
| Дундаж үзүүлэлт |                                                 | 41,5% | 36,6% | 15,6%  | 5,9%    |

Судалгаанд хамрагдсан 45 сурагчдын 41,5% нь сурах арга барил сайн эзэмшсэн гэж өөрсдийгөө үнэлсэн, 36,6% нь дунд зэрэг эзэмшсэн гэж үнэлсэн, 15,6% нь тааруухан эзэмшсэн гэж үнэлсэн, 5,9% эзэмшээгүй гэж үнэлсэн байна. Энэ байдалд бид анхаарч сурагч нэг бүрт сурах арга хэр эзэмшсэнээ үнэлэх арга барилтай болоход анхаарч ажиллах хэрэгтэй болсон.

Өнөө үед сурагч сурах арга барил эзэмших, түүнийгээ өөрөө бодитой үнэлэх нь сургалт, хичээлийн үндсэн зорилт болж байна

Сурах аргын 50 үзүүлэлтээс 5 дугаар ангийн сурагчдын сайн эзэмшсэн, эзэмшээгүй арга барилын үнэлгээ гэвэл:

**5 дугаар ангийн сурагчдын сайн эзэмшсэн сурах арга барил бол:**

-сурагч өөрийн өмнө амжилттай суралцах зорилт тавьдаг

-сурагч юмс үзэгдлийг төсөөлөн боддог  
 -сурах хэрэгцээгээ ойлгодог  
 -бусдын яриаг анхааралтай сонсдог  
 -идэвх санаачлагатай  
 -найз нөхдөөс хэрэгтэй мэдээлэл олж авдаг  
 5 дугаар ангийн сурагчдын эзэмшээгүй сурах арга барил бол:  
 -цагийг хуваарилдаг байдал  
 -цагийн хуваарьтай байх  
 -юмс үзэгдлийн гол шинжийг олох  
 -шинэ ухагдахуунд тодорхойлолт өгөх  
 -жишээ, тоо, баримтыг ашиглах  
 -өөрийн зан байдал, харилцаа зэрэгт буй алдаа дутагдлыг олж засч залруулах  
 -багаар ажиллах чадвар  
 -интернетээс хэрэгтэй мэдээлэл олж авах ...  
 5 дугаар ангийн сурагчид сурах зарим арга барилыг сайн эзэмшиж байгаа хэдий ч цөөнгүй

арга барилыг цаашид эзэмших шаардлага байна. Үүнд, багш нэг бүр анхаарч, дээр дурдсан эзэмшээгүй арга барилыг сурагчдад заавал эзэмшүүлэх хэрэгтэй.

### АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Бардин, К.В. (1987). Как научить детей учиться. Москва. Педагогика.
- Монхор, Д., Загдаа, А., Мягмар, Ш. (ред). (1991). Ерөнхий эрдмийн хичээлээр сурагчдад сурах арга барил эзэмшүүлэх зөвлөмж. Улаанбаатар.
- Загдаа, А. (1987). Сурагчдад суралцах арга барил эзэмшүүлэх нь. Сурган хүмүүжүүлэгч. №5, хууд. 50-54.
- Ичинхорлоо, Ш. (1996). Сурагчдад мэдээллийн эх үүсвэрээс бие дааж суралцах арга эзэмшүүлэх арга зам. Дэд эрдэмтний зэрэг горилж бичсэн диссертаци. Улаанбаатар.

ЕБС-ийн багш бүр сурах аргын талаарх мэдлэг, өөрийн арга барилаа тууштай сайжруулах шаардлага байгааг тэмдэглэе.

- Ичинхорлоо, Ш. (2012). Сурах арга. Улаанбаатар.
- Лошкарёва, Н.А. (1990). Формирование общеучебных умений и навыков школьников как составная часть учебно-воспитательного процесса. Автореферат диссертации доктора педагогических наук. Москва.
- Лурье, С. (1990). Сегодня и завтра. Курьер. ЮНЕСКО.
- Нэргүй, С. (1987). Сурагчдад сурах арга эзэмшүүлэх нь. Сурган хүмүүжүүлэгч.
- Усова А.В., Бобров, А.А. (1987). Формирование у учащихся учебных умений. Москва.